

21



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

### Хүнсний хангамж, хөдөө аж ахуйн салбарын технологит ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын зээл олгоход шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд зөвлөсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан зээлийн Засгийн газраас хариуцан төлөх хүүгийн хөнгөлөлт 13.0 нэгж хүртэл хувийг төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуунд зөвшөөрсүгэй.

3. Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт үхэр сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч жижиг, дунд аж ахуйн нэгжийн зээлийг сангийн хөрөнгөөр батлан даах нөхцөлийг бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөл (Г.Пүрэвсүрэн)-д зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Х.БОЛОРЧУЛУУН

